

ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	2
1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл.....	2
1.2 Төсөл хэрэгжих талбайн байршил.....	2
ХОЁР. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ.....	5
2.1 Хүний нөөц:.....	5
2.2 Тоног төхөөрөмж:.....	5
2.3 Хүчин чадал.....	7
2.4 Төслийн дэд бүтцийн шийдэл:.....	7
ГУРАВ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ.....	8
3.1 Төслийн гол болзошгүй нөлөөлөл.....	8
3.2 Сөрөг нөлөөллийг багасгах, арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж.....	9
ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	11
4.1 Зорилго.....	11
4.2 Зорилт.....	11
4.3 Хамрах хүрээ:.....	12
4.4 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	13
4.5 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ.....	14
4.6 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ.....	15
4.7 Түүх соёлын дурсгалыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ.....	15
4.8 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ.....	15
4.9 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	17
4.10 Удирдлага зохион байгуулалт.....	18
4.11 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөө.....	18
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	
Хүснэгт 1 Төслийн талбайн солбицол.....	2
Хүснэгт 2 Тоног төхөөрөмжийн жагсаалт.....	5
Хүснэгт 3 Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим, хугацаа.....	8
Хүснэгт 4 Төслийн гол сөрөг нөлөөлөл.....	9
Хүснэгт 5 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ.....	10
Хүснэгт 6 2025 оны төлөвлөсөн БОМТ-ний нэгтгэл мөнгөн дүн.....	12
Хүснэгт 7 Сөрөг нөлөөлөл бууруулах арга хэмжээ.....	13
Хүснэгт 8 Нөхөн сэргээлтийн үед хэрэгжүүлэх арга хэмжээ.....	14
Хүснэгт 9 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	15
Хүснэгт 10 Осол эрсдэлийн менежмент.....	17
Хүснэгт 11 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	18
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	
Зураг 1 Төслийн талбайн байршил.....	3
Зураг 2 Агуулах үүдэн талаасаа.....	3
Зураг 3 Агуулах баруун талаасаа.....	4
Зураг 4 Агуулах урд талаасаа.....	4

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Төслийн нэр:	“Газар тариалангийн зориулалттай ургамал хамгааллын бодис, бордоо болон малын тэжээлийн нэмэлтийг импортлох, хадгалах, худалдах”
Төсөл хэрэгжүүлэгч:	“Кэм тэк” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9011585148
Регистрийн дугаар:	6047637
Хаяг:	Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, 12/1, “Ochir center” 7 давхрын 701-Б тоот
Утас:	88116879

1.2 Төсөл хэрэгжих талбайн байршил

“Кэм тэк” ХХК нь 2016 оноос хойш ургамал хамгааллын бүтээгдэхүүний худалдаа болон зөвлөх үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа. 2017 оноос эхлэн хөдөө аж ахуйн химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч “Sinochem Agro” Co., Ltd-ийн албан ёсны төлөөлөгчөөр ажиллаж байна. Мөн хэрэглэгчдэд бүтээгдэхүүнийг үр дүнтэй, зөв зохистой ашиглах арга технологийн талаар зөвлөгөө өгөх мэргэжлийн зөвлөх үйлчилгээг үзүүлдэг.


Хүснэгт 1 Төслийн талбайн солбицол

№	х	у
1	567856.41	5482924.92
2	567867.56	5482880.86
3	567849.27	5482873.88
4	567826.95	5482865.83
5	567751.82	5482838.12
6	567637.15	5482798.91
7	567632.99	5482798.15
8	567631.04	5482803.40
9	567624.04	5482822.13
10	567632.92	5482825.39
11	567625.53	5482848.15
12	567620.54	5482842.54
13	567618.57	5482852.62
14	567620.16	5482853.14
15	567617.49	5482861.40
16	567610.95	5482859.35
17	567609.23	5482865.23
18	567605.71	5482876.24
19	567619.83	5482880.48
20	567619.47	5482881.63
21	567621.12	5482882.18
22	567620.62	5482883.58
23	567619.06	5482883.02

№	х	у
24	567611.37	5482908.32
25	567612.42	5482908.64
26	567608.65	5482919.34
27	567633.04	5482927.62
28	567651.88	5482933.93
29	567697.57	5482949.75
30	567713.65	5482954.82
31	567720.95	5482957.33
32	567718.46	5482964.58
33	567731.14	5482968.59
34	567733.52	5482961.64
35	567758.14	5482970.38
36	567772.09	5482975.09
37	567804.71	5482986.35
38	567803.86	5482990.13
39	567824.82	5482996.63
40	567825.29	5482995.41
41	567847.53	5483002.39
42	567857.15	5482961.62
43	567858.24	5482958.04
44	567847.47	5482955.32
45	567852.17	5482939.17
46	567853.07	5482936.41



Төслийн талбайн байршил



Зураг 1 Төслийн талбайн байршил



Зураг 2 Агуулах үүдэн талаасаа




Зураг 3 Агуулах баруун талаасаа



Зураг 4 Агуулах урд талаасаа

ХОЁР. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ

2.1 Хүний нөөц: Төслийн хүрээнд нийт үндсэн 15 ажилтан, үүнээс улирлын шинжтэй гэрээтээр 3 хүн, үндсэн 12 ажилтантай ажиллахаар төлөвлөсөн. Бүтэц зохион байгуулалтыг дараах схемээр харуулав. Ажилтны ажил мэргэжлийн байдал нь бэлчээр, газар тариалан, газар тариалангийн үйлдвэрлэл, аргобизнесийн үйл ажиллагааны менежер, эргономич болон бусад мэргэжлийн ур чадвартай хамт олноос бүрдсэн байна. Төслийн хүрээнд ажиллаж байгаа ажилтны 20%-ийг орон нутгийн иргэдээс бүрдсэн.







Схем 1 Байгууллагын бүтэц

2.2 Тоног төхөөрөмж:

“Кэм тэк” ХХК-ийн үйл ажиллагааны хүрээнд агуулахын ашиглалтыг хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангасан, ажлын нөхцөлд нэн шаардлагатай төхөөрөмжөөр агуулахыг тохижуулахаар төлөвлөсөн байна. Дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2 Тоног төхөөрөмжийн жагсаалт

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг	Хүчин чадал	Зориулалт	Зураг
1	Цахилгааны ерөнхий самбар	1	<ul style="list-style-type: none"> - IP54 хамгаалалтын зэрэгтэй - Их хүчдэлд өртөх эрсдэлээс хамгаалсан модулийн хаалттай - Олон улсын IEC, ГОСТ стандартуудын шаардлага хангасан тоноглолуудтай - 2 болон 3 цэгийн цоожний системээр түгжигддэг 	Цахилгаан эрчим хүчийг төвлөрсөн хяналт, зохицуулалттай аргаар дамжуулахад зориулагдсан	

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг	Хүчин чадал	Зориулалт	Зураг
			<ul style="list-style-type: none"> - Ашиглалт үйлчилгээ хийхэд төвөггүй байх - 180 градусаар онгойх хаалгатай - Оролт гаралтын кабель холбох аюулгүй, хялбар шийдэлтэй 		
2	Газардуулгын иж бүрдэл	1	<ul style="list-style-type: none"> - Вольт: 220-500kV Богино залгааны гүйдэл: - 6.5-13 kA/1S - Утас: 25-50 mm² - Тусгаарлагчийн урт: ≥ 2100-8000 	Цахилгааны системийн хамгаалалт болон аюулгүй байдлыг хангах	
3	Ослын үеийн гэрэлтүүлэг	10	<ul style="list-style-type: none"> - Хүчдэл: AC220V/240V 50/60Hz - Гэрлийн эх үүсвэр: LED/20ш 5050 - Хувьсах гүйдлийн хүч: 6W¹/2W² - Зай: Ni-Cd 3.6v 2.5Ah - Онцгой байдал үргэлжлэх хугацаа: ≥3 цаг - Материал: Галд тэсвэртэй ABS суурь+PC бүрхэвч 	Тог цахилгаан тасарсан үеийн гэрэлтүүлэг	
4	Ослын дохиолол	2	Дуут дохиолол нь тус байгууламжид ажиллаж буй бүх ажиллагсад сонсогдохуйц чанга, орчны дуу чимээ, тээврийн хэрэгслийн дуут дохионоос ялгагдахаар байна	Агуулах нь ослын үед ажиллах автомат ажиллагаатай дуут дохиолол	
5	Гал унтраах автомат төхөөрөмж	10	<p>Төрөл: ABC 6 kg auto</p> <p>Галын ангилал: 3A 55 B C</p> <p>Хоосон жин: Ф 152 mm</p> <p>Бүхэл жин: 500 mm</p> <p>Ажлын даралт: 14 Bar</p> <p>Турших даралт: 25 Bar</p> <p>Цацрагын урт: ≥ 2.5 метр</p> <p>Ажиллах хугацаа: ≥ 10 сек</p> <p>Хадгалах температур: -300C ~ 600C</p> <p>Ажиллах температур: 680C -700</p>	Галын ослын үед автомаар ажиллаж гал унтраах зориулалттай	

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг	Хүчин чадал	Зориулалт	Зураг
6	Чийг, температур хэмжигч	2	Хэмжилтийн алдаа: 1°C Хэмжилтийн нарийвчлал: 0,1°C, >-20°C; 1C, <-20°C Хэмжих хязгаар: хязгаар температур: -50°C~+70°C, чийг: 10%-99%	Агуулах доторх температур, чийгийг хэмжих хянах	
7	Агуулахын тэргэнцэр	2	500 кг-н даацтай төмөр тэргэнцэр; 110см х 80см х 170см хэмжээтэй (Хоёр давхар)	Агуулах дотор бүтээгдэхүүн зөөвөрлөх	
8	Агуулахын тавиур	20	2500 кг-н даацтай; 250см х 100см х 300см хэмжээтэй	Агуулахад бордоо болон ургамал хамгааллын бодисыг өрж тавих	
9	Сэрээт авто ачигч	1	2500 кг өргөх хүчин чадалтай	Ачаа барааг өндөрт тогтвортойгоор өрж тавих зориулалттай	

2.3 Хүчин чадал

Төсөл хэрэгжүүлэгч “Кэм тэк” ХХК нь ургамал хамгаалах бодис нийлүүлэн ажиллаж байгаа туршлагатай бөгөөд энэ төслийн хүрээнд өөрийн үйл ажиллагааг улам тэлэх, хэрэглэгчдэд хүрч үйлчлэх зорилгоор компанийн байршлыг Дархан-уул аймагт төвлөрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Төслийн хүрээнд нийтдээ 195 нэрийн ургамал хамгаалах бодис, бордоо, малын тэжээлийн нэмэлт зэргийг тухайн жилийн квот хэмжээтэй нийцүүлж импортлохоор төлөвлөсөн. Үүнээс 116 нэр төрлийн химийн бодис нь ургамал хамгаалах бодисыг, 79 нэр төрлийн химийн бордоог нийлүүлэлт хийхээр төлөвлөсөн байна.

2.4 Төслийн дэд бүтцийн шийдэл:

Зам харилцаа: Тус төсөл байрших хэсэгт зам харилцаа хөгжсөн, хатуу хучилттай асфальтан замтай.

Барилга, байгууламж: 2464.3 м.кв талбайтай, үйлдвэрлэл, агуулахын зориулалттай барилга байгууламжийг түрээслэн үйл ажиллагаагаа явуулна. Агуулах нь камержуулсан, орчны гэрэлтүүлэгтэй, гадаад талбай хатуу хучилтаар хучигдсан байна.

Одоо байгаа агуулахыг төсөл хэрэгжүүлэгч нь Монгол улсын стандарт MNS 6458:2014 “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага”-д нийцүүлэн агуулахыг тохижуулахаар төлөвлөсөн.

Цэвэр, бохир усны хангамж: Агуулахын байр нь төвийн шугамд холбогдсон. “Дархан-Ус суваг” ХК-тай Цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах гэрээтэй.

Цахилгаан хангамж: Агуулахын байр нь төвийн шугамаас цахилгаан эрчим хүчээр хангагдсан. “Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ХК-тай 2024 оны 5- р сард шинэчилсэн гурван жилийн гэрээтэй.

Дулаан хангамж: Дулааны хангамжийг “Дарханы Дулааны Сүлжээ” ТӨХК-тай байгуулсан гэрээний дагуу дулаанаар хангагддаг.

ГУРАВ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

3.1 Төслийн гол болзошгүй нөлөөлөл

Байгаль орчинд төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх гол сөрөг нөлөөллийг тодорхойлбол:

- Химийн бодисыг тээвэрлэх явцад алдаа гаргаж асгах, хөрсөнд алдах, бодисуудын битүүмжлэл алдагдах үүнээс үүдэлтэй бодисын ууршилт үүсэх, агаар орчин болон хөрсөн бүрхэвч химийн бодисоор бохирдох.
- Бодисоор бохирдсон хаягдлын зохицуулалтгүй байх эсвэл зохицуулалт муу байх, ил задгай хаях тохиолдолд хөрс, ургамал бохирдох.
- Байгаль орчны бүрдэл хэсгүүдээс нөлөөлөлд өртөх гол бүрдэл хэсэг нь хөрс, агаар байхаар байна. Ургамал хамгаалах бодис, бордоог ашиглах зааварчилгаа, технологи аргачлалгүй худалдан борлуулах, үүнээс үүдэлтэй буруу хэрэглээнээс үүдсэн хордлого, хоруу нөлөөлөл үүсэх.

Төслийн гол сөрөг нөлөөллийг химийн бодис импортлохоос эхлэн худалдах хүртэлх бүхийл үе шатанд авч үзэв. Төслийн үйл ажиллагааны явц дахь нөлөөлөл нь үйл ажиллагаа эрхлэгчдийн ажлын туршлага, дүрэм журмын хэрэгжилт зэргээс ихээхэн хамаарна.

Хүснэгт 3 Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим, хугацаа

№	Төслийн гол сөрөг нөлөөлөл	Нөлөөлөлд өртөгч	Хамрах хүрээ	Нөлөөллийн эрчим	Хугацаа
1.	Химийн бодисын хаягдал, хог хаягдлын угаагдал хөрсөнд шингэх	Орчны хөрс	-	Боломж бага	Хавар, зуны улиралд
2.	Химийн бодисын буруу хадгалалт	Агаар, хүн	Агуулахын ойр орчим	Их	Төслийн туршид
3.	Химийн бодисын тээвэр	Хүн, байгаль	Төслийн хэмжээнд	Их	Тогтоох боломжгүй
4.	Химийн бодисын хэрэглээ	Хүн	Төслийн хэмжээнд, хэрэглэгч	Хүчтэй	Тогтоох боломжгүй

Төслийн үйл ажиллагааны хүрээнд байгаль орчинд нөлөөлөх гол сөрөг нөлөөллийн эх үүсгэвэр нь үйлдвэрлэлд ашиглах химийн бодис, мөн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдал, эрчим хүчний зохисгүй хэрэглээ, усны зохисгүй хэрэглээ байхаар байна

Хүснэгт 4 Төслийн гол сөрөг нөлөөлөл

Үйл ажиллагааны төрөл	Химийн бодисын гол сөрөг нөлөөлөл	
	Хүний эрүүл мэндэд	Байгаль орчинд
Агуулахын үйл ажиллагаанаас гарах хог хаягдал	<ul style="list-style-type: none"> - Хүнээс хамаарсан эмх замбараагүй байдал буюу хог хаягдал ил задгай хаях, хог хаягдлын менежментийг бүрэн хэрэгжүүлэхгүй байхаас үүдэлтэй хөрсний бохирдол, агаар орчны бохирдол үүсэх. 	<ul style="list-style-type: none"> - Хөрс, ус, агаарт шууд болон дам сөрөг нөлөө үзүүлэх. - Агаарт эвгүй үнэр тархах болон хийн бохирдол үүсгэх, хортон, өвчин үүсгэгч бактери үржих.
Химийн бодис худалдах, хэрэглэх үед	<ul style="list-style-type: none"> - Мэргэжлээс шалтгаалах өвчин үүсэх - Химийн бодистой ажиллах үеийн гэнэтийн осол, өртөлтөөс үүсэх хурц хордлого, харшил, эрхтэн системийн гэмтэл гэх мэт. 	<ul style="list-style-type: none"> - Усан орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх - Усны амьтдад нөлөөлөх - Усан орчны организмд удаан хугацаагаар нөлөөлнө.
Химийн бодис хадгалах үед	<ul style="list-style-type: none"> - Агуулахын ангилан хадгалалт алдагдах, хамт хадгалах хориотой бодисуудыг нэг дор хадгалагдах: үүнээс үүдэн осол тохиолдох магадлал нэмэгдэх. - Их хэмжээгээр нэг дор хадгалах үеийн эмзэг байдал бий болох, осол аваарын эрсдэл нэмэгдэх. /химийн хорт хийн холимог үүсэх, хэрэглэх бодис андуурагдах гэх мэт/ 	<ul style="list-style-type: none"> - Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтын үеийн аюулгүй ажиллагаа алдагдах, осол аюулын улмаас химийн бодис уурших замаар агаар, хөрсний хими, физик шинж чанарыг өөрчлөх, бохирдуулах, орчинд тархах. - Химийн бодисын сав баглаа боодол болон ахуйн хог хаягдлыг журмын дагуу зайлуулж, устгаагүй, ил задгай хаях зэргээс байгаль орчинд бохирдол үүсэж болзошгүй.
Тээврийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт	<ul style="list-style-type: none"> - Хүний эрүүл мэндэд дам сөрөг нөлөө үзүүлнэ. 	<ul style="list-style-type: none"> - Орчны агаарын чанарт сөргөөр нөлөөлөх - Тоосжилтын түвшин нэмэгдэх

Химийн бодисыг тээвэрлэх, хадгалах үеийн аюулгүй ажиллагааны дүрэм, журам, зааврыг баримтлан ажиллаагүй нөхцөлд санамсаргүй асгарч, алдагдсанаас агаар, ус, хөрсийг бохирдуулах, хатуу шингэн хаягдлын хэмжээг нэмэгдүүлэх, ажиллагсдын эрүүл мэндэд эрсдэл учруулах зэргээр богино хугацаанд байгаль орчин болон ажиллагсдын эрүүл мэндэд шууд нөлөөлөх сөрөг нөлөөллийн эрчмийг нэмэгдүүлж болзошгүй байна.

3.2 Сөрөг нөлөөллийг багасгах, арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж

Дархан-Уул аймгийн Дархан сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт “Кэм тэк” ХХК-ийн хэрэгжүүлэх “Газар тариалангийн зориулалттай ургамал хамгааллын бодис, бордоо болон малын тэжээлийн нэмэлтийг импортлох, хадгалах, худалдах” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд үндэслэн төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчинд үзүүлэх болзошгүй болон гол сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг бууруулах, арилгахад дараах зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллах, шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авч хэрэгжүүлэхийг төсөл хэрэгжүүлэгч “Кэм Тэк” ХХК-ийн удирдлагад зөвлөж байна.

Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн үйл ажиллагаатай холбогдох хууль, дүрэм, журам, стандартын шаардлагыг хангаж ажиллахаас гадна химийн бодисын онцлог шинж чанар, хор аюул, хадгалалт, тээвэрлэлт, худалдан борлуулах талаар ажиллагсад мэдлэг олгож, болзошгүй сөрөг

нөлөөлөл, осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд авах арга хэмжээний талаар дотоод дүрэм, журам боловсруулан мөрдөж ажиллах нь зүйтэй.

Хүснэгт 5 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

№	Төслийн гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ
1.	Энгийн хог хаягдлаас үүдэлтэй орчны бохирдол үүсэх.	<ul style="list-style-type: none"> - Хогийн цэгийг сайжруулан тохижуулах, хөрсийг хатуу хучилттай болгох; - Тогтсон хугацааны давтамжтай, тогтмол ачин зайлуулах; - Хогийн цэгт байнга ариутгал халдваргүйжүүлэлт хийх; - Ил задгай хаяж орчныг бохирдуулахгүй байх; - Эх үүсвэр дээр нь ангилан ялгаж байгаа процессыг сайжруулах; - Дахиврыг хэрэглэгч байгууллагад дахин боловсруулахаар шилжүүлэх;
2.	Тээврийн хөдөлгөөн ихсэх, тоосжилт нэмэгдэх	<ul style="list-style-type: none"> - Орчны хөрсийг тогтмол цэвэрлэх, нөхөн сэргээх, зүлэгжүүлэх, мод тарих; - Төв замаас төслийн талбай орох хэсгийн замыг сайжруулах, тоосжилт үүсгэхгүй байх арга хэмжээ авах; - Замыг засаж сайжруулах, тэмдэглэгээ хийх, явган хүний зорчих замыг хийж тохижуулж, асфальтаар хучих зэрэг арга хэмжээ авах; - Төслийн талбайн дотоод тохижилтыг сайжруулах, ногоон байгууламж нэмэх;
3.	Химийн бодисоор агаар, хөрс бохирдох	<ul style="list-style-type: none"> - Агааржуулалтын системийн ажиллагааг байнга хянаж хэвийн ажиллагаатай байлгах, агааржуулалтын систем мембран шүүлтүүртэй байх, тогтмол хугацаанд сольдог байх; - Бодис хадгалж байгаа савыг битүүмжлэл сайтай байлгах; - Хадгалах, тээвэрлэх, ашиглах үеийн аюулгүй ажиллагааны заавар боловсруулан мөрдөж ажиллах; - Агуулахыг хариуцсан мэргэжлийн хүн ажиллуулах; - Бодисын хор аюулын талаарх мэдээлэл, танилцуулах самбар тэмдэг тэмдэглэгээг агуулахад ил байршуулах; - Химийн бодистой холбоотой сургалт семинар байнга зохион байгуулах; - Гадаргын болон газрын доорх усанд алдахгүй, хаяхгүй байх; - Химийн ослоос урьдчилан сэргийлэх, ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх;
4.	Химийн бодист өртөх, хүн амьтанд хортой аюултай нөлөө үзүүлэх	<ul style="list-style-type: none"> - Химийн ШУ, хими технологийн чиглэлээр суралцсан мэргэжлийн хүн ажиллуулах; - Бодисын хор аюул, нөлөөллийн талаарх мэдээ мэдээлэл өгөх сургалт байнга зохион байгуулах; - Байгальд ил задгай хаяхгүй байх; - Бодистой ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг өдөр бүр өгөх; - Зааварчилгаа, дүрэм журмыг мөрдөн ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих; - Болзошгүй осол эрсдэлээс ямагт урьдчилан сэргийлж анхаарал болгоомжтой ажиллах, эрсдэл тохиолдсон үед хэрэглэх хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэл, гал унтраах багаж хэрэгслийг бэлэн байлгах;
5.	Химийн бодисоор бохирдсон хортой, аюултай хог хаягдал орчныг бохирдуулах	<ul style="list-style-type: none"> - Аюултай хог хаягдал үүсгэгчийн код авах; - Хог хаягдлын тухай хуулийг мөрдөж ажиллах; - Химийн бодисын сав баглаа боодлыг худалдан авагч нараасаа тоо ширхгээр нь буцаан татан авч түр хадгалах; - Аюултай хог хаягдал цуглуулж түр хадгалах тусгай цэг, хадгалах агуулах гаргаж хяналттай байлгах; - Химийн бодисоор бохирдсон материал, эд зүйл, хугацаа дууссан бодис урвалж зэрэг аюултай хог хаягдлыг ангилан хадгалах;

№	Төслийн гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ
		<ul style="list-style-type: none"> - Бохирдсон бүх зүйлийг тусгайлсан хогийн цэгт түр хадгалах; - Аюултай хог хаягдлыг хуульд заасны дагуу хэмжээнээс хамааран 90 хоног хүртэл хадгалах; - Эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй байгууллагатай эрх шилжүүлэх гэрээ хийх, дагалдах маягт бүртгэлийг хөтөлж бүртгэх; - Эрх шилжүүлэхдээ дагалдах бичиг баримтыг бүрдүүлж ажиллах; - Аюултай хог хаягдлын тайланг жил бүрийн 11 сард гаргаж харьяа дүүргийн Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэст албан тоотоор хандан хүргүүлэх; - Дээрх үйл ажиллагаануудын хууль эрх зүйн үндсийг доор тусгав. Үүнд: - Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ - Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам /2018, 116-р тогтоол 1 дүгээр хавсралт/
6.	Химийн бодисын тээвэрлэлт, түүнтэй холбоотой аюул эрсдэл гарах /гэнэтийн осол аваар, техникийн бүрэн бус байдал, жолоочийн хариуцлагагүй байдал/	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын “Химийн ослоос урьдчилан сэргийлэх, ослын үед ажиллах төлөвлөгөө”-нд тээвэрлэлтийн үйл ажиллагааг сайтар нарийн тусгаж, химийн бодис тээвэрлэлтийн маршрутаа батлан хавсаргах; - Тус төлөвлөгөөнд “Бодисыг бага хэмжээгээр асгах үед авах арга хэмжээ, саармагжуулах арга”, “Бодисыг их хэмжээгээр асгах үед авах арга хэмжээ, саармагжуулах арга”-ыг тус тус нарийвчлан тусгаж өгөх, харьяа дүүргийн ОБГ-аар шинэчлэн хянуулж батлуулах; - Тогтоосон маршрутаас ангид тээвэр хийхийг хатуу хориглох; - MNS 4978:2017 Аюултай ачаа. Ангилал. Тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлагыг хангасан тээврийн хэрэглэлээр тээвэрлэлтийг хийх; - Хэрэв өөрсдөө тээвэр хийдэг бол Аюултай ачаа тээвэрлэх тусгай зөвшөөрөл авах; - Өөрсдөө тээвэр хийх боломжгүй тохиолдолд тусгай зөвшөөрөл бүхий тээвэрлэлтийн компаниар тээвэрлэлтийг гүйцэтгүүлэх;

“Химийн хорт болон аюултай бодисын тухай” хуулийн холбогдох заалтууд, Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 54/А/136/А/215 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”-ыг мөрдөн ажиллах шаардлагатай. Мөн тус тайлангийн 1 болон 2 дугаар хүснэгтэд заасны дагуух хууль эрх зүйн баримт бичиг, стандартуудыг мөрдөж ажиллах шаардлагатай.

ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

4.1 Зорилго

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутагт дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилготой.

4.2 Зорилт

1. БОННУ-гээр дүгнэгдсэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээнүүдийг шат дараатай авч ажиллах

2. Нутгийн уугуул иргэдтэй нээлттэй харилцаж, байгаль орчинд халгүй нөхцөлийг бүрдүүлж хамтран ажиллах
3. Мэдээллийн ил тод байдлыг хангаж, нутгийн иргэд болон засаг захиргааны нэгжүүдтэй нягт уялдаатай ажиллах зорилтуудыг тавьж ажиллана.

4.3 Хамрах хүрээ:

Манай төслийн хувьд хамрах хүрээгээ өөрийн төсөл хэрэгжих газар талбайд төдийгүй, харьяа нутаг дэвсгэрийн ус, хөрс, ан амьтан хамгаалах, үргэж зайлахаас сэргийлэн ажиллахаар төлөвлөж байна.

Хүснэгт 6 2025 оны төлөвлөсөн БОМТ-ний нэгтгэл мөнгөн дүн

Д/д	Бүрэлдэхүүн хэсгүүд	2026 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1,295.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө /ногоон байгууламжийн төлөвлөгөө/	1,500.0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол , Химийн эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	4,000.0
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	5,440.0
8	Удирдлага зохион байгуулалт	-
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	580.0
Нийт		12,815.0

4.4 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 7 Сөрөг нөлөөлөл бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /мян.төг/	Тоо хэмжээ	Нийт зардал, /мян.төг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1. Агаар орчин								
1	Агуулах болон орчинд төслийн үйл ажиллагаанаас агаарын бохирдол үүсгэх	Орчны болон ажлын байрын агаарын бохирдлын байдалд жилд 2 удаа шинжилгээ хийлгэх /2 цэгт/	Агуулах, агуулахын гадаад орчин	удаа	35.0	2 цэгт 2 удаа	140.0	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль
2	Машин техникийн утаа	Орчны тоосжилт үүсгэхгүй байхад анхаарч, ил гарсан элэгдэлд орсон хөрсийг зүлэгжүүлэх	Төслийн эзэмшил газарт	удаа				Агаарын чанар - Хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063:2010
2. Дуу чимээ								
3	Ашиглагдаж буй машин, тоног төхөөрөмжөөс үүссэн дуу чимээ орчны шуугианы түвшнийг нэмэгдүүлнэ.	Машин тоног төхөөрөмжийг дуу шуугиан хамгийн бага тарах нөхцөлтэйгөөр байршуулан ашиглах	Агуулах байранд	--*--	--*--	--*--	--*--	MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 дуу чимээ – хэвийн норм- түвшний хэмжээ
4		Ажиллагсдыг дуу шуугианаас хамгаалах хэрэгслээр хангаж хэрэгжүүлэх	Ажиллагсад	удаа	5	5 хүн, жил бүр	125.0	
5		Дуу шуугианы хэмжилт (1 цэгт дууны түвшин хэмжигч NL-04 багажаар) хийх. /Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори/	Агуулахын байранд, хашаанд	удаа	15.0	-	30.0	
3. Усны нөөц, чанар								
6	Төслийн явцад газрын гадарга, гүний ус бохирдуулах шууд бус нөлөөлөлтэй	Усны бохирдол үүсгэхээс урьдчилан сэргийлэх, ОХШХ хэрэгжүүлэх	Төслийн хүрээнд	--*--	--*--	--*--	ҮАЗ-д тусгах	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /мян.төг/	Тоо хэмжээ	Нийт зардал, /мян.төг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
4. Хөрс, ургамлын бүрхэвч								
7	Ахуйн бохирдол үүсэх	Агуулахын гадна хог хаягдлыг хадгалах зориулалтын битүүмжилсэн хогийн савны сайжруулалт хийх, ангилан ялгалттай болох	Агуулах, өөрийн эзэмшил талбайн хогийн цэгт	--*--	--*--	--*--	1,000.0	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
8	Химийн бодис алдагдах, ажиллагсдын хайнга үйл ажиллагааны улмаас орчны хөрсөнд бохирдол үүсэх;	Агуулах болон гадна талбайд цэвэрлэгээ, арчилгааг тогтмол хийж байх, аюултай хог хаягдлыг тусгайлсан түр хадгалах хогийн цэг гарган хадгалах	Агуулах, төслийн хүрээнд	--*--	--*--	--*--	ҮАЗ-д тусгах	
9	Холбогдох дүрэм журмын хэрэгжилт хангагдахгүй байх хүн байгальд сөрөг нөлөөлөл үүсэх	Химийн бодисын болон аюултай хог хаягдлын тайлан гаргаж, холбогдох төр захиргааны байгууллагад цаг хугацаанд нь тайлагнах	Төслийн хүрээнд	--*--	--*--	--*--	--*--	
Эхний 5 жилийн дүн							1,295.0	

4.5 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ

Хүснэгт 8 Нөхөн сэргээлтийн үед хэрэгжүүлэх арга хэмжээ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян/төг	Нийт зардал, мян/төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Нөхөн сэргээлт	“Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ний хүрээнд харьяа баг, сумтай хамтран төлөвлөлттэйгөөр мод тарих, арчлан ургуулах	удаа	100	1000	1,000.0	4 болон 10 дугаар сард	MNS 5914-2008- Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт. MNS 5918:2008

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян/төг	Нийт зардал, мян/төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
2		Орчны ногоон байгууламжтай талбайд цэвэрлэгээ хийх, зүлэгжүүлэх, тохижилтыг сайжруулалт хийх	-	-	500	500	хавар	<i>Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага</i>
Нийт						1,500.0		

4.6 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ

Тухайн төсөл хэрэгжих газар нь Дархан уул аймгийн Дархан сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах ба төслийн чиглэл, хүчин чадал, үйл ажиллагаатай холбоотойгоор хүн амыг нүүлгэх шаардлагагүй юм.

4.7 Түүх соёлын дурсгалыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ

Төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа явуулж буй тус газар нь суурин бүсэд байрладаг. Тухайн талбайд түүх соёлын дурсгалт зүйл илрээгүй бөгөөд төслийн хэрэгжилтийн үед түүх соёлын дурсгалт зүйл илэрсэн тохиолдолд харьяалах орон нутгийн байгаль орчны газар, соёлын өв хариуцан ажиллаж буй ажилтан албан байгууллагад хандан мэдэгдэх үүрэг хүлээнэ.

4.8 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ

Төсөл хэрэгжүүлэгч “Кэм тэк” ХХК нь “Газар тариалангийн зориулалттай ургамал хамгааллын бодис, бордоо болон малын тэжээлийн нэмэлтийг импортлох, хадгалах, худалдах” төслөөс үүсэх хог хаягдлаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бага хэмжээнд байлгахад төлөвлөх нь зүйтэй бөгөөд хөрсийг бохирдуулахгүйн тулд хог хаягдлыг түр хадгалах цэгт ангилан битүүмжлэлтэй саванд байршуулах, энэ талаар зохих мэдлэгийг ажиллагсад өгч ажиллах нь зүйтэй юм.

Хүснэгт 9 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Давтамж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, /мян.төг/	Нийт зардал, /мян.төг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	4	5	6	7
1	Болзошгүй осол, саатал, техник технологийн болон шугам сүлжээний	Үйл ажиллагаанд ашиглах төхөөрөмж, галын гидрант, галын дохиоллын системтэй байх, аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Барилга байгууламж техник тоног төхөөрөмжид	сар бүр	12	--*--	ҮАзардалд	Гамшгаас хамгаалах тухай хууль, 27.1; Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Давтамж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, /мян.төг/	Нийт зардал, /мян.төг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	4	5	6	7
2	гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх. Байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ. Химийн бодисоос үүсэх осол эрсдэл	Галын болон байгалийн аюул гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Бүх ажилчдад	удаа	5	--*--	ҮАзардалд	Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны агаар дахь хорт бодисыг хэмжихэд тавих ерөнхий шаардлага, зөвшөөрөх дээд хэмжээ. MNS 4990:2023
3		Химийн бодистой харьцаж ажиллах ажилчдад химийн бодистой ажиллах, аюул ослын үед авах арга хэмжээний сургалт зохион байгуулах		удаа	5	--*--		
4		Осол эрсдэл үүссэн үед устгах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Төслийн хүрээнд	удаа	1	--*--	--*--	
5		Ажилчдыг ажлын хувцас, хамгаалалтын тусгай хэрэгслээр (хөвөн даавуун материалаар хийсэн хувцас, резинтэй хормогч, резинтэй гутал, резинтэй бээлий, хамгаалалтын нүдний шил, маск) хангах	Төслийн хүрээнд	удаа	12	--*--	ҮАзардалд	
6		Галын аюулгүй байдлын дүгнэлт авах	Төслийн хүрээнд	удаа	1	--*--	--*--	
7		“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй тухай” хуулийн 31,2-т “Шинээр ажлын байр бий болгох болон ажлын байрны үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл өөрчлөгдөх бүрд, химийн хорт болон аюултай бодис агуулсан түүхий эд, материал ашиглаж үйл ажиллагаа явуулж байгаа бол жилд нэгээс доошгүй удаа ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэнэ” гэсэн заалтын дагуу хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж байх.	Төслийн хүрээнд	Жил бүр	Жил бүр	--*--	4,000.0	
Эхний 5 жилийн дүн							4,000.0	

4.9 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 10 Осол эрсдэлийн менежмент

№	Хог хаягдлын ангилал /Болзошгүй сөрөг нөлөөлөл/	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, /мян.төг/	Тоо хэмжээ	Нийт зардал, /мян.төг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
1	2	3	4	5	6	7	8		
1	Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Хатуу хог хаягдлыг ялгах, зайлуулах, дахин боловсруулалтад оруулах	Төслийн хүрээнд	удаа	120	12	1,440.0	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд	
2	Аюултай хог хаягдлын хуримтлал үүсэх, ахуйн хог хаягдалтай холилдох	Химийн бодис, шингэн хог хаягдал асгарсан тохиолдолд тухай бүрд нь арилгаж байх материалыг /элс, хаягдал зориулалтын шингээгч даавуу гэх мэт/ нөөцлөн бэлдэх	Төслийн хүрээнд	Тухай бүр	-	-	500.0	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд,	
3		Аюултай хог хаягдал хадгалах түр цэг байгуулах	Төслийн хүрээнд	удаа	1	Эхний жил	2,000.0		
4		Аюултай хог хаягдал боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий байгууллагад хүлээлгэн өгөх	Төслийн хүрээнд	удаа	2	-	1500.0		
5	Хийн хаягдал гарч агаар орчин бохирдож болзошгүй. /бодисын шуудай, асгарсан бодис урвалж арчсан материалууд /	Худалдан авагч байгууллагуудтай гэрээлэн химийн бодисын сав баглаа боодлыг эгүүлэн татах менежменттэй ажиллах	Төслийн хүрээнд	Тухай бүр	--*--	Тухай бүр	--*--		
Эхний 5 жилийн дүн								5440.0	

4.10 Удирдлага зохион байгуулалт

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, /мян.төг/	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Аймгийн байгаль орчны газарт	Цаасан болон цахим хэлбэрээр	БОМТ-ний хэрэгжилт болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийн тайлан	Жил бүрийн 11-р сарын 01-ны дотор	--	Байгаль орчны менежер	--
2	БОУАӨЯ-ны ХБОБНУГ-т	Цаасан тайлангаар /цахим тайлан/	БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийн тайлан	Жил бүрийн 11-15-ны дотор	--	Байгаль орчны менежер	--

4.11 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөө

Хүснэгт 11 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, /мян.төг/	Нийт зардал, төг /мян.төг/	Тайлбар	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
1	2	3	4	5	6	7	8	
Агаарын чанар								
1	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх	Агуулахын байр, агуулахын гадаад орчинд 1 цэг сонгох	жилд 2 удаа	2	55.0	110	PM 2.5, PM10 Тоосонцор, хүхэрлэг болон азотлог хий, дуу чимээ шинжлүүлэх	MNS 4585-2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, Хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063:2010; Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны агаар дахь хорт бодисыг хэмжихэд тавих ерөнхий шаардлага, зөвшөөрөх дээд хэмжээ. MNS 4990:2023
Усны чанар								
2	Унд ахуйн усны хяналтын шинжилгээ	Унд ахуйн уснаас хагас жилд 1 удаа	жилд 2	2	115	230.0	Физик-химийн болон нянгийн бохирдол, хүнд металл	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж; MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага.
Хөрсний бохирдол								

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, /мян.төг/	Нийт зардал, төг /мян.төг/	Тайлбар	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
	1	2	3	4	5	6	7	8
3	Хөрсний төлөв байдал, бохирдол	Төслийн талбайгаас (агуулахын үүдний хэсгээс)	Жилд 2 удаа.	2	120	240.0	агрохими, хүнд металл	MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага
Эхний 5 жилийн дүн						580.0		

